



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/213

Арвайхээр


**Хөрөнгө зарцуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.10, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдварын (COVID-19) болзошгүй тохиолдол, бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, орчны өвчин үүсгэгч нян, вирусыг устгах зориулалт бүхий ариутгал, халдваргүйтгэлийн мананцар үүсгэгч "Пог" машин худалдан авах зардалд 1,820,000 (нэг сая найман зуун хорин мянга) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх 1,820,000 (нэг сая найман зуун хорин мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100489